

" Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай "Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны 230 дугаар тогтоолыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх ба тогтоолд улсын бүртгэлийн цахим үйлчилгээний системээс лавлагааг үнэ төлбөргүй олгохоор тогтоосон болно.

Энэхүү тогтоолтой холбоотой e-mongolia.mn-ээс үзүүлэх УБЕГ-ын бүх лавлагаа үнэ төлбөргүй болсон болно.

1	Төрсний бүртгэлийн лавлагаа
2	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа
3	Гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа
4	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэлийн лавлагаа
5	Регистрийн дугаарын тухай лавлагаа
6	Регистрийн дугаар сольж, шинээр олгосон тухай лавлагаа
7	Овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлийн лавлагаа
8	Үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлгүй тухай лавлагаа
9	Үндэсний энгийн гадаад паспорт анх удаа авсан тухай лавлагаа
10	Үндэсний энгийн гадаад паспорт дахин авсан тухай лавлагаа
11	Иргэний үнэмлэхийн лавлагаа
12	Оршин суугаа хаягийн лавлагаа
13	Цахим бүртгэлд хамрагдсан эсэх лавлагаа
14	Хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй эсэх лавлагаа
15	Хуулийн этгээдийн бүртгэлгүй тухай лавлагаа
16	Хуулийн этгээдийн хаягийн лавлагаа
17	Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа
18	Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн тухай лавлагаа
19	Хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн тухай лавлагаа
20	Хуулийн этгээд татан буугдсан эсэх лавлагаа
21	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа
22	Үл хөдлөх эд хөрөнгөтэй эсэх лавлагаа
23	Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа
24	Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа /насанд хүрээгүй хүний/